

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭНЭТЭМНИЙН УХЛААНЫ ФАКУЛЬТЕТ

ТҮҮЖ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ № 488 (14) 2002 он

RUSSIA



Гарчиг

Эрхэм уншигч Танаа

5

Монголын түүх

1. П.Дэлгэржаргал. Мэнгу шивэй аймгийн угсаа гарлыг нэхэн сурвалжлах нь. 8
2. Д.Хүүхэнбаатар, П.Дэлгэржаргал. Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөний түүхийн асуудал. (XX зууны эхний хагас). 12
3. Д.Энхцэцэг. Үндэсний эв нэгдэл- тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн баталгаа болох нь. 18
4. Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь гадаадынхны үйл ажиллагаа. 23
5. З.Лонжид. Дундат иргэн улсаас Монголын тухай баримталсан бодлогыг нэхэн судлахуй. (1919 оноос хойш) 29
6. С.Отгонжаргал. XX зуунд Монголд гарсан хөрөнгөлөг ардчилсан хувьсгалын асуудалд. 34
7. Н.Хишигт. Монголын түүхэнд Барон Унгерний холбогдох нь /1921-1925/ 42
8. Б.Пунсалдулам. Монгол дахь Буриадын хурал. 51

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

1. Б.Ралгаа. Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн нь. 57
2. С.Түвшин. Ж.Цэвээний улс төр, нийгэм-эдийн засгийн үзэл баримтлалын тухайд. 68
3. З.Баасанжав. МУИС байгуулагдсан түүхээс. 73
4. Л.Ариунаа. Монголд өөрөө удирдах ёсны түүхэн уламжлал байсан уу? (Бодрол, тэмдэглэл). 78

Байгаль хамгаалах түүхэн уламжлал

1. Ж.Болдбаатар, С.Дэмбэрэл. Монголчуудын байгаль орчноо хамгаалах зан заншил, хууль тогтоомжийн түүхэн тойм (Нэн эртнээс XX зуун). 80
2. Л.Чулуунбаатар. Ган зудын гамшиг, гэтлэн давах арга замын тухайд. 99

Гадаад харилцааны түүх

1. Ута Шёне. 1920-иод онд Герман улсад суралцаж байсан монгол сурагчдад болон Лайпцигт хэвлүүлсэн монголын газрын зургийн түүхэнд холбогдох зарим тэмдэглэл. 104
2. Р.Төрдалай. Франц улсын Парис хотын монгол сурагчид /Түүхэн тэмдэглэл/. 110

Түүх бичлэг

1. Удо Баркманн. Монголын түүхийн талаархи олон улсын судалгаа: Эзгүйрэл, улс төрийн ашиг хонжоо хоёрт идэгдсэн Монголын түүх. 114
2. Б.Пунсалдулам. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын тухай түүх бичлэгийн зарим асуудалд. 127

Түүхэн газар зүй

1. Д.Сүхбаатар. Монгол орны түүхэн газар усны нэрийн тухай. 133

Хавсралт

1. Түүхийн салбарыг төгссөн алдартнууд 137
2. Зохиогчдын товч танилцуулга 139

**1920-иод онд Герман улсад суралцаж байсан монгол
сурагчдад болон Лайпцигт хэвлүүлсэн монголын газрын
зургийн түүхэнд холбогдох зарим тэмдэглэл**

Доктор /Sc/ Ута Шёне /ХБНГУ/

1926 онд Ардыг Гэгээрүүлэх Яамны шийдвэрээр анхны дунд сургуулийн сурагчдаас 31 хүүхэд залуусыг сонгон, Герман улсад дунд болон мэргэжлийн аль нэгэн сургуульд сургахаар явуулжээ. Насанд хүрсэн 6 хүнийг мөн ондоо нэмэн илгээжээ. 1929/30 онд эх орондоо гэдрэг татагдсан монгол суралцагчид Герман улсын аль аль хотуудад ямар мэргэжлээр, ямар сургуульд суралцаж байсан талаарх судалгаа эдүгээ болтол дутмаг хийгджээ. Харин сүүлийн хэдэн жилд нийтэлсэн тухайн үеийн түүхийн гэрч хүмүүсийн намтарт болон Германд суралцаж байсан зарим хүмүүсийн дуртгал, тэмдэглэл шинэ мэдээ сэлт нилээд тусгагджээ. Бас Монгол Улсын Түүхийн Төв Архивын сан хөмрөгт хадгалагдаж буй 1927 оны үед Герман, Франц улсад суралцаж байсан монгол сурагчдыг хариуцагч багш, Ардыг Гэгээрүүлэх яамны төлөөлөгч Ишдоржоос Германы сургууль, шинжлэх ухаан, соёл, худалдаа, үйлдвэр, пүүс, албан газартай болон хувь хүнтэй харилцаж байсан 500 орчим задгай хуудас бүхий захидал материалд монгол суралцагчдад холбогдох зарим асуудлыг тодруулан мэдэж болох чухал баримтууд байна. Голдуу германаар, түүнчлэн бас орос, франц, англи хэлэн дээр машиндсан эдгээр баримт, мөн Ишдоржийн монгол бичгээр бичсэн тэмдэглэл зэрэгт тулгуурлан нэгдүгээрт: 1927 онд монгол суралцагчдын оршин сууж байсан хот, суралцаж байсан сургууль, эзэмшсэн мэргэжилд холбогдох асуудлыг улам тодотгох, хоёрдугаарт: сургуульдаа богино хугацааны дотор сайн дассан бөгөөд Ишдоржтой тохиролцсоны дагуу тэдэнд герман хэл, математик, газрын зүй, физик гэх зэргийн хичээл хэсэг хугацаанд тусгайлан заалгаад тэнцэх ангид суралцуулах бэлтгэл болзлыг ерөнхийдөө хангасан талаар өгүүлжээ.¹ Бас сурагчдын зан ааш, хүмүүн төлөв, сэтгэлийн хөдөлгөөн, хүн чанар, хичээл зүтгэлийг тэмдэглэсэн зарим сонин зүйл бий. “Берлин-Лихтерфелде дэх улсын сургалтын газар хэмээх сургуульд таван хүүхдийг элсүүлэв”² гэж Ишдоржоос 1927 оны 3-р сарын 2-нд Кеслин хотын сургуульд илгээсэн захидалдаа тэмдэглэсэн байна. Гэтэл Лихтерфелде-гийн сургуулиудын жил тутмын тайлангийн тухайн оны дугаараас лавлан үзэхэд гадаадын сурагчдын нийт тоо, тэдний шашин шүтлэгийн тухай дурдсан зүйл байх боловч чухам аль орны сурагчид тэр сургуульд суралцаж байсныг нарийвчлан тэмдэглэсэн баримт хараахан олдоогүй байна. Мөн түүнчлэн 1927-1929 онуудад сургууль төгсөгчдийн дотор монголын 5 сурагчийн нэр, овог ор тас орхигджээ.³ Ийм учраас монгол сурагчид 1927 онд Берлин-Лихтерфелде-гийн сургуульд суралцаж байсан эсэх нь одоо хүртэл олдоод байгаа баримтаас үзвэл нотлогдохгүй байна. Харин насаараа хамгийн эгчмэд байсан улмаас дээр дурдсан 19 сурагчийн тоонд ороогүй Пагдадуламын тухайд бол Ишдорж гар бичмэл тэмдэглэхдээ. “... Пагдадулам болбоос /Лайпциг хотын – У.Ш./ бүсгүйчүүдийн дунд сургуульд орсон бөгөөд ер дунд сургуулийн хугацаа 4 жил боловч тэр сургуульд сайнаар оролдвоос 3 жилийн дотор төгсгөж гаргаж болох”⁴ гэжээ.

Дээр дурдсан хоёрдугаар бүлэгт хамааруулж болох 10 суралцагчдын 7 нь Лайпциг хот дахь хоёр хэвлэлийн газарт газар зүй, ном хэвлэлийн мэргэжлээр, Айзанах хотын “Дикси” автомашины үйлдвэрт нарийн механикчийн мэргэжлээр, Берлин хот дахь “Уфа” киноны нэгдэлд гэрэл зураг, кино техникийн мэргэжлээр тус тус суралцаж байжээ. Харин үлдэх гурван залуу нь мөн онд Саксон мужийн

Фрайберг хотын арьс боловсруулах сургуулийн бэлтгэл ангид суралцаж байв. Үүнээс үзэхэд монголын тал өөрийн оронд чухал хэрэгцээтэй нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх асуудлыг гол болгохдоо Германд явуулсан хүүхдүүдээ юуны өмнө техникийн мэргэжлээр суралцуулдаг байжээ. Монгол сурагчдыг хариуцагч багш нар 1927 онд дээр дурдсан сургуулиас гадна Мекленбург мужийн Штернбург хотын техникийн тусгай мэргэжлийн дунд сургууль, Коттбус хотын нэхмэлийн тусгай мэргэжлийн дунд сургууль, Бранденбург мужийн Ораниенбург хотын хөдөө аж ахуй, газар тариалангийн сургууль, Хессен мужийн Витценхаузен хотын “Колони сургууль” гэгч хөдөө аж ахуйн сургууль, Мюнхен хотын кино техникийн сургууль зэрэгтэй холбоо тогтоож, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг авч танилцах, монгол сурагчдыг суралцуулахтай холбогдох хүсэлтийг тавьсан ажээ.

XX зууны 20-иод онд Герман улсад явуулсан Нацагдорж зэрэг насанд хүрэгчдийн суралцаж байсан нэгэн сургууль бол Берлин хотын их сургуулийн дэргэдэх “Герман хэлний институт” гэгч сургууль байсан бөгөөд тэнд гадаадын иргэдэд зориулж, герман хэл бичгийн зэрэгцээгээр утга зохиол, түүх, улс орон судлалын хичээл заах дөрвөн дамжааг зохион байгуулсан байв. Одоо Хумбольдтын их сургуулийн архивын сан хөмрөгт хадгалагдаж буй гадаадын суралцагчдын бүртгэлд монголын таван хүний нэр овгийг, тэднийг эрхэлдэг ажил, суудаг хаягийн хамт тэмдэглэсэн байна. Эдгээр баримт сэлтээс үзвэл 1925/26 онд Бат-Очир, Гомбожав нар 5 буюу 4 ийм курст, 1926/27 онд Буддарь, Санжаа нар 2 курст тус тус суралцаж байв гэж тэмдэглэжээ.⁵ Нацагдорж, Пагмадулам нар 1927 оны нэгдүгээр сарын 1-нээс гуравдугаар сарын 26 хүртэл болон мөн оны гуравдугаар сарын 30-наас зургадугаар сарын нэгэн хүртэл тус бүр нийтдээ хоёр курст суралцаж байсан ажээ.⁶ Энэ нь Нацагдорж нарыг Берлин хот дахь “Герман хэлний институт”-д хэдийд суралцаж байсныг тодруулах чухал мэдээ болно. Харин энэ харьцангуй богино хугацаанд герман хэл бичиг хэр зэрэг эзэмшиж, хэддүгээр дамжаа дүүргэж, ямар шалгалт өгч, ер нь курсаа бүрэн төгсгөж амжсан уу гэсэн асуултад хариу өгөх баримтыг тус архиваас олж чадаагүй байна. Ташрамд сонин нэгэн зүйлийг тэмдэглэхэд дээр дурдсан гадаадын суралцагчдыг бүртгэсэн дансанд “Хаана оршин суудаг? Ямар ажил эрхэлдэг вэ?” гэсэн асуултад Нацагдорж, Бат-Очир нар цөмөөрөө “өргөө хотноо оршин суугч”, бас “геологи, инженер, газар тариалан, улс төрийн судалын оюутан”, зарим нь зөвхөн “оюутан” /жишээ: Нацагдорж, Пагмадулам/ буюу “зохиолч” /Бат-Очир гэж хариулсан байна.⁷

Одоо бидний гарт байгаа баримтаас үзвэл 1927 оны байдлаар Монголоос Германд ирээд ямар нэгэн сургууль хийж байсан хүний тоо нь нийтдээ 40-д хүрсэн бололтой. Гэтэл хориод оны байдлаар гэвэл монгол суралцагчдын нийт тоог тодорхойлоход бэрхтэй юм. Одоогоор үүнийг хэлэх хараахан боломжгүй юм. Мөн түүнчлэн 1928 оны 10-р сард “Остойропа” /Зүүн Европ/ хэмээх сэтгүүлд Ишдорж нийтлүүлсэн өгүүлэлдээ “Сүүлийн 4 шахам жилийн турш Герман, Франц улсын сургууль, үйлдвэрийн газарт улсынхаа зардлаар суралцахаар бараг 150 хүнийг илгээв.”⁸ гэж бичсэнийг нягтлан үзвэл энэ тоо нь бодит байдалд хараахан нийцгүй мэт санагдана. Тэрбээр Франц, Герман улсад явуулсан суралцагчдын төдийгүй, мөн Зөвлөлт хийгээд бусад оронд байсан суралцагчдыг давхар хамааруулсан бололтой.

1924/25 онд Ардыг Гэгээрүүлэх Яамны сайд Эрдэнэбатхаан Герман улсад зорчихдоо монгол оюутан, сурагчдыг Германы сургуульд суралцахаар явуулах асуудлыг холбогдох газартай хэлэлцэж байсны гадна герман сурах бичгүүдийг орчуулах бололцоог эрэлхийлж, Германаас кино, гэрэл зургийн төхөөрөмж, бичгийн машин зэргийг захиалуулах, Монголын сургуульд зориулсан атлас,

Монголын газрын зураг хэвлүүлэх асуудлыг шийдвэрлэж байжээ. Ийнхүү Лайпциг хотын Вагнер, Дебес нарын хэвлэлийн пүүст Эрдэнэбатхаан сайдын захиалгаар хананд өлгөх зориулалттай 1:2000000 масштаб бүхий Монголын улс төр, газар дүрсийн зураг 1000 ширхэг, тал бөмбөрцөгийн зураг 1000 ширхэг, 12 хуудастай сургуулийн атлас 10000 ширхэгийг тус тус хэвлэжээ. Тус хэвлэлийн пүүсийн 1927 оны 1-р сарын 27-ны өдрийн едрийн захиалгын нэхэмжлэгээс үзвэл газрын зураг хэвлэхэд зарцуулсан нийт зардал 19500 райхс-марк болжээ.⁹ Арван найман хайрцагтай атлас, газрын зургийг мөн оны 7-р сарын 29-нд “Пройссен” хэмээх усан онгоцонд ачиж, Ленинград руу илгээсэн байна.¹⁰ Газрын зургийн анхны хэвлэл гарсны дараа монголын тал түүнийг өргөтгөн засварлаж, хоёрдахь удаа хэвлэхээр төлөвлөж байсан боловч хэвлэлтэнд орсон эсэх тухай баримт одоо хир олдохгүй байна. Бас Берлин хотын Шарлоттенбург дүүрэгт суудаг байсан монгол сурагчдыг хариуцагч багш нараас Вагнер, Дебес нарын пүүстэй харилцаж байсан захидлаас үзвэл Монгол улсын Ардыг Гэгээрүүлэх Яам Азийн болон бусад тивийн өнгөт газрын зургийг Лайпцигт монгол бичгээр олон хувь хэвлүүлэхийг ихэд сонирхож байсан. Тийм ч учраас томъёолсон тайлбар тэмдэггүй газрын зургийг Монголд явуулахыг хүссэн байна.¹¹

Монголын газрын зураг хэвлэх ажил хоёр талын бие оролцогчдын аль алинд нь цоо шинэ зүйл байв. Жишээ нь: градусын шугамтай буулгадаг цаасанд улс орны нэр усыг монгол бичгээр бичих нь маш нарийн, түвэгтэй чимхлүүр ажил байсан тул Монголд монгол хүнээр хийлгэсэн юм. Харин бичгийн чанар нь германы хэвлэлийн эздийн санасанд арай хүрэхгүй болсон бололтой. Тийм учраас Вагнер, Дебес нарын пүүсийнхэн “монголоор бичихдээ анхнаасаа алдаагүй бичвэл зохино. Тэгэхгүй бол анхны удаагийнх шиг нэгэнт бичсэн үгийг олон дахин засахад хүрвэл зураас нь улам бүр зузаан гарна” гэж монголын талд зориуд анхааруулсан байв. “Техникийн” энэ асуудлаас гадна үгсийн сантай холбогдох өөр нэгэн асуудал газрын зургийн зохиогчдын өмнө тулгарчээ. Энэ тухай 1928 оны “Остройпа” хэмээх сэтгүүлийн анхны дугаарт нийтэлсэн өгүүлэлдээ Ишдорж бичихдээ” ... монгол улсын сургуульд үзэх атлас, ханын газрын зургийг анх удаа монгол бичгээр хэвлэхийн тулд газар зүйн олон шинэ нэр томъёог төвд, самгарьд хэлний үгсийн санд тулгуурлан бий болгожээ.”¹³ гэжээ.

1926 оны сүүлчээр Лувсаннамжил, Аюурзана гэгч хоёр залуу Лайпцигийн Вагнер, Дебес нарын хэвлэлийн газарт газар зүйн мэргэжлээр дадлага хийж суралцахаар очжээ. Эдгээр залуусыг дээрх пүүсийн эзэд Ишдоржид 1927 оны 11-р сарын 30-нд бичсэн захидалдаа “төрөлх ” авъяастай бөгөөд ажил хөдөлмөртөө дуртай залуу” гээд “энд ирээд ажилласан богинохон хугацаандаа их юм сурч чадсан нь гайхалтайг” сайшаан тэмдэглэжээ. Цааш нь бичихэд, “Энэ хоёр залуу мэргэжлээ сайн эзэмшихээ өөрийн эрхэм үүрэг гэж үздэг бөгөөд танай улсад тус нэмэр үзүүлж чадах сайн зураг зүйч болно гэдэгт бид итгэж байна.”¹⁴ гэжээ. Гэтэл хоёр жил орчмын дараа Германд суралцаж байсан монгол сурагчдыг, тэдний дотор сайн мэргэжилтэн болох ирээдүйтэй хэмээн сайшаагдаж асан мөнөөх нөгөө хоёр залууг ч Монголын улс төрийн бодлоготой холбогдох шалтгааны улмаас гэдрэгээ татагдах болсон нь туйлын харамсалтай зүйл байв.

Монгол улсын газрын зургийн анхны хэвлэл гарснаас хойш янз бүрийн байгууллага, газар болон хувь хүн Ишдоржид хандаж баяр хүргэж, холбогдох зарим зүйлийг лавлан асууж, заиалга өгөхийг хүссэн байна. Берлин хотын угсаатны зүйн улсын музейн Дорнод Азийн тасгийн захирал Мюллер Ишдоржид болон тус газрын зургийг хэвлэхэд гар бие оролцогчдод баяр хүргэхийн хамт “энэхүү газрын зургууд бол Монгол улсын өсвөр үеийг сурган хүмүүжүүлэхэд зохих хувь нэмэр оруулах төдийгүй танай орны тухай бид өөрийн мэдлэгийг,

тухайлбал, газар зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд их тус болох нь эргэлзээгүй юм.” гэж бичжээ. Бас өөр нэгэн жишээ дурдвал Брауншвайг хотын Георг Вестерманн хэмээх алдартай хэвлэлийн газрын эзэн 1927 оны 10-р сарын 12-нд Ишдоржид илгээсэн захидалдаа: “Хэрэв та надад өөрийнхөө орны шинэчилсэн атлас болон газрын зурагнаас тус бүр хоёр ширхэгийг явуулбал би танд нэн талархах болно. Түүнд тулгуурлан би өөрийн хэвлэлийн газартаа хэвлэсэн газрын зургийг өргөтгөн засварламаар байна. Германы сургуульд үзэх Монгол улсын газрын зураг нь танай орны өнөөгийн бодит байдалд аль болохоор нийцтэй байх нь зүйтэй гэсэн саналыг та ч дэмжинэ гэдэгт би итгэлтэй байна.”¹⁶ гэж бичжээ. Мөн түүнчлэн Монгол орны газар зүйн шинэ нэр томъёоны талаар Вестерманн тавьсан асуултад Ишдорж хариулахдаа: ““Өргөө” хэмээх нийслэл хамт бичвэл зүйтэй юм. Харин Маймаачин гэдэг нэрийг одоо хэрэглэгддэггүй. Урьд энэ нэрээр нэрлэж байсан хотыг Алтанбулаг гэх болсон.”¹⁷ Ишдорж Германы сургуульд үзэх атласт Монгол улсын нутаг дэвсгэрийн засаг захиргааны хуваарийг, тухайлбал, “Хан Хэнтий уул, Богд хан уул, Цэцэрлэг Мандал; хан Тайшир уул, Чандмань уул зэрэг 5 аймгийг болон Тагнын нурууны араар оршдог “Танну Тува /Тагна Тува-У.Ш./ хэмээх турз угсаатан нарын бие даасан тусгаар тогтносон Бүгд Найрамдах Улсыг нэмж тэмдэглэвэл зохино”¹⁸ гэж зөвлөжээ.

Монголын газрын зургийг сонирхогч, захиалагчдын тоонд дээр дурдсан Вестерманн зэрэгцээгээр Берлин хотын Раймер-Фосен, Гота хотын Юстус Пертес нарын зэрэг газар зүйн хэвлэлийн газруудаас гадна дотоод, гадаадын шинжлэх ухаан, соёлын олон байгууллагууд, тухайлбал Финландын Хелзинфорз хот дахь Фини-угрын нийгэмлэг, Франц улсын Шинжлэх ухааны Академи болон Прусс улсын номын сан, Германы армийн номын сан, Берлины угсаатны зүйн музей, Дорнод Европын судлалын германы нийгэмлэг, Берлиний их сургуулийн хятадын судлалын семинар, Бээжин хотод суугаа “Фоссишө Цайтунг” хэмээх алдартай сонин газрын сурвалжлагч зэрэг байгууллага, хувь хүн орсон байна.

1927 оны 12-р сард дээр дурдсан хятадын судлалын семинарт Ишдоржоос илгээсэн монголын газрын зургийн нэг хувь нь одоо Берлины Хумбольдтын их сургуулийн Ази, Африкийн судлалын фондод хадгалагдсаар байна. Түүнийг хэвлэн гаргасан газар, оныг тодруулбал доод талд нь “Монгол улсын Ардыг Гэгээрүүлэх Яамнаас хэвлүүлэн гаргабай. Арван зургадугаар он” гэж бичсэн байна. Энэхүү хананд өлгөх зориулалттай газрын зургийг 127/83 см-ийн хэмжээ бүхий хар-цагаан өнгөөр папыролин хэмээх даавуун артай цаасан дээр хэвлэсэн байх бөгөөд дээд, доод талд нь нарийн савх мод барьж бэхэлжээ. Тус газрын зураг дээр тухайн үеийн хэллэгээр “Их нийслэл, бага хот ба хийд, өртөө, төмөр зам, хөсгөөр харилцах зам, зам, цахилгаан мэдээ” зэрэг томъёолсон тэмдгийг тусгайлан тавьсан нь хориод оны үеийн Монгол улсын засаг захиргаа, хот суурин, харилцаа холбоо, тээврийн ерөнхий шинж байдлыг мэдэж болох чухал нэгэн хэрэглэгдэхүүн болно. Ташрамд хэлэхэд энэхүү газрын зураг дээр Монгол улстай хил залгадаг Шинэжаан муж, Танну Урианхай, Шилинголын чуулган, Уланцавын чуулган зэргийг тус тус тэмдэглэсэн бий. 1926 онд хэвлэсэн энэ газрын зургийг одоогийнхтой харьцуулбал Монгол улсын хил нь зарим хэсгээрээ, тухайлбал Увс нуур, Номингийн говь, Замын үүдийн хавиар зөрөөтэй зурагджээ. Дээр дурдсан бүхнээс үзэхэд Монгол улсын Ардыг Гэгээрүүлэх яамнаас 20-иод онуудад Герман улсад хэвлэн гаргасан газрын зураг нь монгол-германы харилцааны түүхийг судлах явцад судалгаа шинжилгээний сонирхолтой нэгэн баримт болох нь дамжиггүй.

Зүүлтийн цэс.

¹ УТТА, Ф.6, 151, Х. 36,53,99,129 ба Ф.6, ХН. 153, х. 121.

² УТТА, Ф.6, ХН. 153,х. 164.

³ Берлин хотын багш нарын мэргэжил дээшлүүлэх ба сургууль хөгжүүлэх институтийн /БИЛ/ архивт хадгалагдаж буй 1926/27, 1927/28, 1928/29 оны хичээлийн жилийн тухай Берлин-Лихтерфельде дэх улсын сургалтын газрын тайланг үз. /герман хэлээр/

⁴ УТТА, Ф.6, ХН. 153, х.57.

⁵ Берлины их сургуулийн “гадаад иргэдэд зориулсан герман хэлний институт”-ийн мэдээ, 1923-1928 онууд, 1925 он /5 дугаар, 1926 он/ 1,2,3,4,5,10,11-дугаар; 1927 он/ 2,4,8-дугаар. Об. 2052 /герман хэлээр/

⁶ мөн тэнд, 1927 он/ 2-дугаар, 10 дахь тал ба мөн он/ 4 дүгээр, 26 дахь тал.

⁷ мөн тэнд

⁸ Иши-Доржи, Өнөөгийн Монгол улс, соёлын бүтээн байгуулалт. “Остройпа” хэмээх сэтгүүл, 1928 он, 1-р дэвтэр, 404/405 дахь тал /герман хэлээр/

⁹ УТТА, Ф.6, ХН. 152,х.11,30

¹⁰ УТТА, Ф.6, ХН.152, х. 69

¹¹ УТТА, Ф.6, ХН.152, х.11,28,30

¹² УТТА, Ф.6, ХН. 152,х. 13

¹³ Иши-Доржи, Өнөөгийн Монгол улс,... 405 дахь тал. /герман хэлээр/

¹⁴ УТТА, Ф.6, ХН. 152,х. 11,30

¹⁵ УТТА, Ф.6, ХН. 152,х. 24

¹⁶ УТТА, Ф.6, ХН. 152,х. 43

¹⁷ УТТА, Ф.6, ХН. 152,х. 73

¹⁸ Мөн тэнд.

Гадаад харилцааны түүх

Хавсралт 1

Герман улсад суралцаж байсан монгол сурагчид /1927 оны байдлаар/

Нэр овог	Хүйс	Нас/ төрсөн он	Сургууль, сургалтын газрын хаяг	Сургуульд элссэн он	Суралцагч дын нийт тоо
Бадар /чин/ Г.Батсүх Гомбо Д.Намдаг Л.Намхайцэрэн Т.Нацагдорж Сэдэд Цэвээн Цэрэнханд Г.Хаалаа	Эр Эм Эр Эр Эр Эр Эр Эм Эм	13 16/1911 15	Тюринген мужийн Викарсдорф хотын чөлөөт сургуулийн газар /хувийн дунд сургууль/	2-р сар	10
С.Бавуу Б.Доржсүрэн С.Наваан-Юндэн Пүрэвдорж Б.Содном	Эр Эр Эр Эр Эр	17/1910 16 19/1908	Берлин-Лихтерфельде дэх улсын сургалтын газар /улсын дунд сургууль/	2-р сар	5
М. Лувсан цэнд Д.Сурмаажав Ш.Цэвэг /Цэвэг/ Юмхүү	Эр Эм Эр Эм	15 14	Летцлинген дэх чөлөөт хөдөлмөр-сургуулийн газар /хувийн дунд сургууль/	2-р сар	4
Базарнямаа /Нямаа/ Лувсан	Эр Эр	18	Айзенах хотын "Дикси" автомашины үйлдвэр	2-р сар	2
Содном /Бага С./ Сомади Юмбуу	Эр Эр Эр	16	Саксон мужийн Фрайберг хотын арьс боловсруулах сургууль	2-р сар бэлтгэл курс	2
Аюурзана Лувсанамжил	Эр Эр	16	Лайпциг хот дахь Вагнер, Дебес нарын үзүүлсэн таниулах материал хэвлэх газар	Урьд оны 11-р сар	2
Баатарсэнгээ Лувсандамдин /Дамдин/	Эр Эр	16 15	Лайпциг хот дахь Прийс-хавар И.Б.Хиршфельд нарын хэвлэлийн үйлдвэр		2
Гомбожав Сумъяа /?/	Эр Эр	25/1902 16	Коттбус хотын нэхмэлийн тусгай мэргэжлийн дунд сургууль	Тодорхойгүй	2
Н.Бат-Очир	Эр	24/1903	Берлин хот дахь "Уфа" киноны нэгдэл; Берлины гэрэл зурагч д-р Рефелдер	Тодорхойгүй	1
Д.Санжаа	Эр		Берлин хотын их сургуулийн дэргэдэх "гадаад иргэдэд зориулсан" "Герман хэлний институт" Бранденбург мужийн Ораниенбург хотын "Луизенхоф" хэмээх хөдөө аж ахуй, газар тариалангийн сургууль	III/30-VI/1 VI/16-VIII/10 8-р сар /?/	1
Д.Нацагдорж	Эр	1906	Берлины "Германы хэлний институт", Лайпциг хотын их сургууль	I/31-IV-1	
Д.Пагмадулам	Эм		"Герман хэлний институт", Лайпциг хот дахь охидын дунд сургууль	9-р сараас /?/ зочний хувиар I/31-IV/1 тодорхой-гүй	2
Баасан /Баваасан/ Д.Буддарь Б.Далай Рэгзэн Сосор Даваа Цэрэндамба	Эр Эр Эр Эр Эр Эр	15/1912 1895 1906 1913	Тодорхойгүй "Герман хэдний институт мөн адил" тодорхойгүй тодорхойгүй тодорхойгүй	I/31-II/26 мөн адил	6
НИИТ					40

